

БАТЛАВ.
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ
2025 оны 01 дүгээр сарын 02 өдөр

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Тоо чанар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд				
1.	Төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, энэ талаар харьяалах байгууллагад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх	Жилдээ	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Салбарын зөвлөлийн гишүүд
2.	Төрийн албаны зөвлөлийн ажлын албанд Салбар зөвлөлийн ажлын тайлан, мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлэх	Хуулийн хугацаанд	Мэдээ, тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
3.	Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тайлагнах	Улирал тутам	Салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж, төрийн албан хаагчидтай холбоотой аливаа асуудал тухай бүр шийдвэрлэгдсэн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
4.	Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр батлуулан, хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хуралдааны шийдвэр, тэмдэглэл зохих журмын дагуу албажиж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргэгдсэн байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

5.	Салбар зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах, шийдвэрийн биелэлтийг хангуулах	Жилдээ	Салбар зөвлөлийн тогтоол, хуралдааны тэмдэглэл албажиж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
6.	Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой болон бусад мэдээ, тайлан, судалгаа гаргах	Жилдээ	Хүргүүлсэн тайлан, мэдээ, судалгааны тоо: Хугацаанд нь үнэн зөв гаргаж хүргүүлсэн байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
7.	Салбар зөвлөлийн архив, албан хэрэг хөтлөлт, төрийн болон албаны нууцын асуудлыг хангах	Жилдээ	Хадгаламжийн нэгжийн тоо: Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулсан байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
Хоёр.Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах				
1.	Ерөнхий газар болон харьяалах байгууллагын хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөнийг "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, журам"-д заасны дагуу зохион байгуулах	Жилдээ	Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдсэн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
2.	Сул болон түр эзгүй байгаа орон тоог нөхөх ажлыг "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу зохион байгуулах	Жилдээ	Сул болон түр эзгүй байгаа орон тоог хууль тогтоомжийн хүрээнд нөхсөн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
3.	Сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс байгуулах, албан тушаалын сул орон тоонд зохих журмын дагуу нэр дэвшүүлэх, нэр дэвшүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих	Жилдээ	Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хамгийн сайн хангасан хүнийг чадахуйн зарчимд үндэслэн сонгон авах, сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
4.	Төрийн албаны зөвлөлөөс "Албан тушаалын тодорхойлолт" хянах чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	Жилдээ	Хууль тогтоомжид өөрчлөлт орсон тохиолдолд "Албан тушаалын тодорхойлолт"-ыг боловсруулж Төрийн албаны зөвлөлд журмын дагуу хүргүүлсэн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

5.	Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв шинээр болон ахиулан олгох асуудлыг Салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангах	1 дүгээр улиралд	Төрийн жинхэнэ албан хаагчийн судалгаанд үндэслэн, журмын дагуу шийдвэрлэсэн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
6.	Төрийн албан хаагчийг холбогдох журамд заасны дагуу шагнаж, урамшуулах санал гаргах	Жилдээ	Төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах, нэр дэвшүүлэх.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
7.	Шинээр батлагдан гарсан салбарын болон Төрийн албаны тухай хууль тогтоомж түүнийг дагалдан гарсан эрх зүйн актуудыг хэрэгжүүлэх, сурталчлах ажилд хяналт тавих	Жилдээ	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
8.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэлт гаргах	Жилдээ	Батлагдсан хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийг Салбар зөвлөлд танилцуулсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
9.	Удирдлагын академийн 2025 онд улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу Төрийн албаны мэргэшүүлэх болон Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад хамруулах, хяналт тавих	Жилдээ	Албан тушаалын тодорхойлолтод тавигдах шаардлагад нийцсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
10.	Төрийн байгууллага, төрийн албан хаагчийн талаарх мэдээ, мэдээлэл, материал, судалгааг харьяалах байгууллагаас гаргуулж авах, дүгнэлт гаргах	Жилдээ	Салбарын төрийн албан хаагчдын судалгааг үнэн, зөв гаргасан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
Гурав.Цахим мэдээллийн санд суурилсан хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд				
1.	Ерөнхий газар болон харьяалах байгууллагын "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим систем"-д тухай бүр мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд оруулах, Хүний нөөцийн мэдээллийг бүртгэх, хүний нөөцийн дотоод болон гадаад үйл ажиллагааг автоматжуулах	Жилдээ	Төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн санд давхцалгүй, үнэн зөв мэдээлэл бий болсноор бүх түвшний хэрэглэгчид өөрийн эрх, үүргийн хүрээнд нэгдсэн тайлангаар хангагдах, мэдээлэл дээр дүн	Нарийн бичгийн дарга Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

			шинжилгээ хийх, тоонд суурилсан шийдвэр гаргах боломжууд бүрдэнэ.	
2.	Ерөнхий газар болон харьяалах байгууллагын албан хаагчийн тоо бүртгэл хөтлөхөд иргэдийг нөөцийн санд хамаарах мэдээллээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх	I улиралд	"Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн статистикийн албан ёсны мэдээний маягт, нөхөх заавар"-ын дагуу 1-20 хавсралтаар бэлтгэн 2022 оны 3 дугаар сарын 16-ны дотор гарган хүргүүлсэн байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
3.	Салбар зөвлөлийн үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтэд ил тод, нээлттэй хүргэн сурталчлах, цаг үеийн мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудас, дотоод сүлжээнд байршуулж мэдээлэх	Тухай бүр	Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн байна. Олон нийтийг холбогдох мэдээллээр хангасан байна. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар олон нийтийн /иргэд/ үнэлгээ.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Мэдээлэл, технологийн холбогдох нэгжүүд
Дөрөв.Төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх ажлын хүрээнд				
1.	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах сургалт, сурталчилгаа зохион байгуулах, арга зүйгээр хангах, зөвлөгөө өгөх	Жилдээ	Хамрагдсан албан хаагчийн тоо: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
2.	Харьяалах төрийн байгууллагын хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Жилдээ	Салбарын 1 байгууллагыг сонгон, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Салбар зөвлөлд танилцуулсан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга
3.	Авлигын тухай болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажилд хяналт тавих	Жилдээ	Авлигатай тэмцэх газартай хамтран ажилласан байна.	Салбар зөвлөлийн гишүүд, Нарийн бичгийн дарга